

“НЭГ ЦОНХНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2014 ОНЫ ТАЙЛАН

2014-12-25

Ховд

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн “Нэг цонхны үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай” 153 дугаар тогтоолоор баталсан Нэг цонхны үйлчилгээний төвийн үйл ажиллагааны журмыг хэрэгжүүлж, иргэдэд үзүүлж байгаа үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэн зохицуулж, үйлчилгээний шат дамжлагыг багасган, үйлчилгээг нэмэгдүүлэх, иргэдэд төрийн үйлчилгээг нэг дор, түргэн шуурхай, нээлттэй, ил тод байх нөхцлийг бүрдүүлэхэд анхаарч аймгийн Засаг даргын 2013 оны А/495 дугаар захирамжаар Нийгмийн халамж үйлчилгээг 3, нийгмийн даатгалын үйлчилгээг 1, иргэний бүртгэлийн үйлчилгээг 2, газрын харилцааны үйлчилгээг 1, хөдөлмөр, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих үйлчилгээг 1, нийт 8 мэргэжилтэн ажиллаж байна.

Нэг цонхны үйлчилгээний төвийн үйл ажиллагааны талаарх мөн цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаар тус төвийн мэргэжилтнүүдтэй удаа дараа уулзан санал солилцож, аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн мэргэжилтэн С.Хоролсүрэнг нэг цонхны үйлчилгээний төвийн ахлагчаар сонгон тэдний санал хүсэлт ажиллах нөхцлийг сайжруулах талаар хамтран санал солилцон ажиллаж байна.

“Нэг Цонхны Үйлчилгээний тогтвортой байдлыг хангахад иргэд ба төрийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх нь” сэдэвт хэлэлцүүлэгийг аймгийн Иргэний танхимд 2014 оны 11 дүгээр сарын 05-ны өдөр зохион байгуулж, хэлэлцүүлэгт Швейцарийн хөгжлийн агентлагийн Засаглалыг дэмжих, төвлөрлийг сааруулах хүрээнд “Иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх нь” төслийг хэрэгжүүлэгч “Хүний аюулгүй байдлын судалгааны төв” ТББ, “Нутгийн удирдлагын түвшинд иргэдийн оролцоог дэмжих нь” төслийг хэрэгжүүлэгч АНУ-ын Азийн сан болон аймгийн Засаг даргын Тамгын газар, Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар, багийн иргэдтэй хамтран зохион байгуулж, хэлэлцүүлэгт аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн дарга, “Нэг цонхны үйлчилгээ”-ний төвийн мэргэжилтнүүд, нэг цонхны үйлчилгээний төвөөр төрийн үйлчилгээг үзүүлдэг харьяа байгууллагуудын удирдлагууд болон иргэдийн төлөөлөл оролцов.

Жаргалант сумын иргэний бүртгэлийн улсын бүртгэлийн талаар:

Тайлант онд Жаргалант суманд Иргэний бүртгэлийн чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэжээ.

Иргэний шинэчилсэн бүртгэл, цахим үнэмлэх олголтын талаар: 2014 онд 16 нас хүрч иргэний үнэмлэх авах 516 хүүхэд, 25 насны сунгалт 334, 45 насны сунгалттай 188 иргэнийг иргэний шинэчилсэн бүртгэлд хамруулж, иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдаагүй, регистрийн дугаарын, овог нэрийн зөрчилтэй 29 иргэнийг мөн ИШБ-д хамруулж цахим үнэмлэх олгох ажлыг хийж гүйцэтгэлээ.

Иргэний цахим үнэмлэх олголтыг НЦҮ- дээр иргэдэд цаг тухайд нь олгож байгаа бөгөөд 2014 оны 10-11 саруудад 16 нас хүрч цахим үнэмлэхээ авсан хүүхдүүдийг аймгийн Ардчилсан залуучуудын холбоотой хамтран “Андгай” өргүүлэн Аймгийн Засаг дарга болон Нийгмийн бодлого хариуцсан Орлогч дарга нарыг оролцуулан цахим үнэмлэхийг нь олгосон нь ихээхэн үр дүнтэй ажил боллоо.

Төрөлт бүртгэлийн үйл ажиллагаа: 2014 онд 856-г бүртгэсэн бөгөөд тухайн тайлант онд эрэгтэй 421, эмэгтэй 435 шинэ төрөлтийг бүртгэн ИУБ маягтуудыг өдөр бүр иргэний 8 төрлийн бүртгэл хариуцсан улсын бүртгэгчид хүргүүлэн өдөрт нь бүртгэлийн санд оруулж байна.

Шинэ төрсөн 856 хүүхдийн материалыг хүлээн авч материал бүрдэлтэнд анхаарч 50 ширхэгээр багцлан архивын нэгж боть үүсгэн архивлалаа.

Эцэг тогтоолтын бүртгэлийн үйл ажиллагаа: Тухайн онд хуучин 39 эцэг тогтоох тухай өргөдөл хүсэлтийг иргэдээс хүлээн авч цаг хугацаанд нь шийдвэрлэн иргэний бүртгэлийн санд оруулсан болно.

Үрчлэлтийн бүртгэлийн талаар: Тухайн онд 24 иргэдээс хүүхэд үрчлэн авах болон үрчлүүлэх тухай хүсэлтийг хүлээн авч, сумын Засаг даргын захирамжаар 24 эцэг эхэд үрчлэлтийн бүртгэлийг хийж гүйцэтгэлээ.

Овог нэр өөрчлөлтийн бүртгэлийн талаар. 2014 онд Ургийн болон эцэг эхийн өөрийн нэрний зөрчилтэй болон өөрсдийнх нь хүсэлтээр нийт 85 иргэний өргөдөл хүсэлтийг хүлээн авсан ба үүнээс ургийн овгийн 41, эцэг эхийн нэрний 19, өөрийн нэрний зөрчилтэй 25 иргэдийн хүсэлтийг хүлээн авч зөрчил дутагдлыг арилган материалыг бүрдүүлэн сумын Засаг даргын захирамжаар өөрчилсөн болно.

Гэрлэлт бүртгэлийн чиглэлээр. 2014 онд гэр бүлээ бүртгүүлэхээр 534 иргэний өргөдөл хүсэлтийг хүлээн авч, 262 гэрлэлт бүртгэн гэрлэлтийн баталгаа олголоо.

Гэрлэлт цуцлалтын бүртгэлийн талаар. Тухайн тайлант онд гэрлэлтээ цуцлуулахаар өргөдөл хүсэлтээ ирүүлсэн 24 иргэний хүсэлтийг хүлээн авч Шүүхийн шийдвэрээр 20, Захиргааны журмаар 4 гэрлэлт цуцлан мэдээллийн санд орууллаа.

Нас баралтын бүртгэлийн чиглэлээр. 2014 онд нийт 163 иргэний нас баралтыг бүртгэснээс эмэгтэй 68, эрэгтэй 95 нас баралтыг бүртгэлийн санд оруулснаас ходоодны хорт хавдраар 16, зүрхний цусан хангамжийн дутагдлаар 41, бөөрний хавдраар 2, амьсгалын замын өвчнөөр 5, цөсний хавдраар 1, тархи судасны өвчнөөр 6, осол гэмтлээр 6, уушигны хатгаа 3, улаан хоолойн хорт хавдар 2, урд булчирхайн хавдар 1, элэгний хавдраар 14 иргэн нас барсан тухай тоо байна.

Шилжилт хөдөлгөөний чиглэлээр. Тайлант онд шилжин явсан 1343, Үүнээс УБ хот болон бусад хот руу шилжин явсан 599, аймгийн доторх сум руу 131 явснаас гадна 194 хүүхэд эцэг эхээ даган шилжин явсан байна. 2014 онд шилжин ирсэн 1180 иргэнийг бүртгэсэн бөгөөд үүнээс УБ хот болон бусад аймаг хотоос шилжин ирсэн 251, аймгийн доторх сумаас 316 иргэн шилжин ирсэн бөгөөд үүнээс баг хооронд

613 иргэн шилжүүлэг хийлгэсэн бөгөөд эцэг эх асран хамгаалагчаа дагаж 32 хүүхэд ирсэн байна. Нийт ирсэнийг багуудад хувааж гаргахад Алаг толгой 54, Баатархайрхан 129, Бичигт 98, Бугат 92, Буянт 151, Жаргалан 69, Магсаржав 81, Наран 107, Рашаант 54, Тахилт 73, Хайрхан 83, Цамбагарав 189 иргэн тухайн багуудын харъяалалд орсон байна.

Бусад ажлын талаар: 2014 оны 1-2 дугаар сард бүх багийн Иргэдийн нийтийн хуралд сууж иргэдийн асуусан асуулт болон Засгийн газар, УБЕГ, аймгийн Улсын бүртгэлээс иргэний бүртгэлийн чиглэлээр гаргаж буй бодлого шийдвэр, хийж зохион байгуулж буй ажлын талаар мэдээллүүдийг тус тус танилцууллаа.

Хийгдсэн бүртгэл нэг бүрийн бүрдүүлбэрийг архивлан сумын хэмжээнд нийт 38 хадгаламжийн нэгж үүсгэв.

Нийгмийн даатгалын үйлчилгээний талаар:

Нэг цонхны үйлчилгээгээр нийгмийн даатгалын хуулийн сургалт сурталчилгаа, сайн дурын болон эрүүл мэндийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх, иргэдийн өргөдөл гомдолд хариулт өгөх, нийгмийн даатгалын хуулиар бүх төрлийн зөвлөгөө өгөх чиглэлээр голчлон үйлчилгээ үзүүлжээ.

Түүнчлэн 1990-2000 оны хооронд ажилласан жил тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 1500 гаруй иргэдийн материал хүлээн авч бүртгэлд оруулсан ба өдөрт дунджаар 20 гаруй иргэдэд баталгаажилтын хуудас тарааж ажиллалаа.

Мөн тэтгэвэрийн хувийн хэргийн материалын бүрдэлт, нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын баталгаажуулалт, шилжилт хөдөлгөөн, ажилгүйдлийн тэтгэмж зэрэг нийгмийн даатгалын бүх төрлийн үйлчилгээ үзүүлсэн.

2014 онд аймгийн төвд болон сум орон нутагт 10 гаруй удаа нийгмийн даатгалын хамрагдалыг нэмэгдүүлэх чиглэлээр “Нээлттэй хаалга”-ны өдрийг зохион явууллаа.

Орон нутгийн Ховд телевизээр 8-10 удаа нийгмийн даатгалын хуулийн сурталчилгаа хийж, ярилцлага уулзалтыг зохион байгуулав.

Нийгмийн халамж үйлчилгээний талаар:

Ховд аймгийн Жаргалант сумын 12 багийн нийт иргэдэд Нийгмийн Халамжийн тухай хуулийг сурталчлан таниулж, дараах үйл ажиллагаа, үйлчилгээг давхадсан тоогоор 20000 гаруй иргэдэд хүргэж ажиллалаа. Ахмад настанд тэтгэвэр авдаг 21 иргэн, нөхцөлт мөнгөн тэтгэмж авдаг 410 иргэн, замын зардал 316 иргэн, рашаан сувилалд 114 иргэн, амралт сувилалд 46 иргэн, түлш 814 иргэн, ХБИргэнд тэтгэвэр авдаг 744 иргэн, нөхцөлт мөнгөн тэтгэмж авдаг 468 иргэн, замын зардал 108 иргэн, рашаан сувилалд 23 иргэн, түлш 395 иргэн, Гавъяат цолтонд замын зардал 18 иргэн, рашаан сувилалд 6 иргэн, түлш 32 иргэн, Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхэд олгох тэтгэмж 1495, “Эхийн алдарт” нэгдүгээр зэргийн одон 870, “Эхийн алдарт” хоёрдугаар зэргийн одонтой эхэд үзүүлсэн мөнгөн тусламж 1532 хүнд дээрх үйлчилгээнүүдийг тус тус үзүүлсэн байна. 2014 онд амжиргаа дэмжих

зөвлөлийг 28 удаа хуралдуулж, хурлаас гарсан шийдвэрийн хэрэгжилтийг ханган ажиллалаа.

2014 онд Нийгмийн халамжийн үйлчилгээ авч байгаа иргэдийн үйлчилгээг ХҮМ программд цаг тухайд нь шивэлт хийж, хувийн хэрэг нээж, мөн иргэдэд зохих хуулийн зөвлөгөө өгч гарын авлагаар хангаж ажилласан. Архив албан хэрэг хөтлөлтийн стандартыг мөрдөж хувийн хэргийн баяжилт хийж, архивт хүлээлгэж өгөх материалуудаа бэлэн болголоо.

Хөдөлмөр, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих үйлчилгээний талаар:

2014 оны 1 сарын 20-с эхлэн “Нэг цонхны үйлгээ”-д Хөдөлмөрийн хэлтсийн Ажлын байрны мэдээлэл,ажил хайгчийн бүртгэл, жижиг дунд үйлдвэрлэл,төсөл хөтөлбөрүүдийн зөвлөгөө мэдээлэл өгч ажиллаж байна. Ажиллах хугацаанд нийт 248 иргэнд зөвлөгөө мэдээлэл өгсөн байна. Нэг цонхны үйлчилгээнд Е бирж суурьлуулж нэг дороос хөдөлмөрийн хэлтсийн бүх мэдээллийг цаг тухай бүрт нь авах боломжтой болсон. Ховд аймагт Хөдөлмөрийн хэлтсийн зохион байгуулсан Олон Улсын “Форум”, “Ховдод үйлдвэрлэв”,“Жижиг дунд үйлдвэрлэлийн үзэсгэлэн худалдаа” болон Хөдөлмөрийн хэлтсийн нээлттэй хаалганы өдөр зэрэг арга хэмжээнүүдэд жижиг дунд үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж,төсөл хэрхэн бичих,төсөлд тавигдах шаардлага гэх мэт ард иргэдэд шууд хүрч үйлчиллээ.

Газрын харилцааны талаар:

Аймгийн газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрыг төлөөлөн иргэдэд кадастрын зураг гаргах, хэмжилт хийх, хяналт тавих, зөрчил арилгахад гол ажлаа төлөвлөн ажиллалаа.Энэ хугацаанд 758 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад баталгаажсан кадастрын зураг, 404 газарт зураглал хийж, 134 иргэний газрын хэмжээ т албай зөрүүтэй иргэдийн зөрчлийг тодруулж, арилгуулах, 212 шилжилт хөдөлгөөн хийгдэж байгаа иргэдийн кадастрын зургийг хэвлэх, улсын бүртгэлд бүртгүүлэх мөн 86 иргэнд хяналтын хэмжилт хийж үйлчилжээ.

Тоон тайланг хавсаргав.

ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТЭС

ХОВД АЙМАГ

2014 ОНЫ IY УЛИРАЛ, ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН МЭДЭЭ

“НЦҮ”-ГЭЭР ҮЙЛЧЛҮҮЛСЭН ИРГЭДИЙН НИЙТ ТОО

2014 он 12 сар 25 өдөр

Үйлчлүүлэгсдийн нийт тоо	Цаг хугацааны хамрах хүрээ	Аймаг/дүүргийн нийт хүн амын тоо	Аймгийн төвийн сумын хүн амын тоо
Нийт тоо 42301	Улирал 2014.10.01- 2014.12.25 Жилийн эцэс 2014.01.02- 2014.12.25	80 217	26342
Эм			
Эр			

**Б. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛ ТУС БҮРЭЭР
ҮЙЛЧЛҮҮЛСЭН ИРГЭДИЙН ТОО**

НЦҮ-ээр үйлчлүүлсэн иргэдийн тоо

Жаргалант сум

2014 оны 12 сарын 25 өдөр

Д/Д	Үйлчилгээ үзүүлсэн газрууд	Үйлчлүүлэгчдийн тоо \сараар\				
		X	XI	XII	I Y у л и р а л	Нийт жилийн эцэс өссөн дүнгээр
1	УБХэлтэс /иргэний бүртгэл/	758	724	663		6192
2	Жаргалант сумын иргэний бүртгэл	124	1108	1113		9828
3	Газрын алба					2153
4	УБХэлтэс / эд хөрөнгийн бүртгэл/					
5	Нийгмийн даатгалын хэлтэс	108	110	130		1340
6	Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс	198	1924	1962		18904
7	Хаанбанк					
8	Нотариат					
9	УБХэлтэс /иргэний бүртгэлийн лавлагаа/	488	384	450		3636
10	УБХэлтэс /хуулийн этгээдийн бүртгэл/					
11	Хөдөлмөрийн хэлтэс	33	23	14		248
	Нийт					42301

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ: (Нийгмийн даатгалын хэлтэс)

№	Үйлчилгээний нэр	“НЦҮ”-нээс үзүүлж байгаа хэлбэр	Үйлчлүүлэгсдийн тоо \сараар\			Нийт жилийн эцэс өссөн дүнгээр
			X	XI	XII	
1	Өндөр насны тэтгэвэр тогтоох	Хэлтсээр шийдвэрлүүлж өгөх	16	9	12	144
2	Ажилгүйдлийн тэтгэмж бодолт, хяналт	Шууд	1	5	2	19
3	НД дэвтэр олгох баталгаажуулах	Шууд	28	31	34	485
4	НД сайн дурын даатгал	Шууд	32	24	39	280
5	ЭМД-н дэвтэр олгох, хураамж төлүүлэх, сунгалт	Шууд	19	27	32	326
6	НД,ЭМД-ын гэрчилгээний шилжилт хөдөлгөөн	Шууд	8	12	6	57
7	Өргөдөл гомдлын шийдвэрлэлт	Шууд болон хэлтсээр шийдвэрлүүлж өгөх	4	2	5	29
	Нийт		108	110	130	1340

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ: (УБХэлтэс иргэний бүртгэл)

№	Үйлчилгээний нэр	“НЦҮ”-нээс үзүүлж байгаа хэлбэр	Үйлчлүүлэгсдийн тоо \сараар\			Нийт жилийн эцэс өссөн дүнгээр
			X	XI	XII	
1	Шилжилт хөдөлгөөн	шууд	283	186	181	2558
2	Иргэний үнэмлэх	Мэдээлэлийн санд шалгах	205	198	269	1078
	Нийт		488	384	450	3636

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ: (НХҮХэлтэс)

№	Үйлчилгээнийнэр	“НЦҮ”-нээс үзүүлж байгаа хэлбэр	Үйлчлүүлэгсдийн тоо \сараар\			Нийт жилийн эцэс өссөн дүнгээр
			X	XI	XII	
1	Тэжээгчээ алдсаны тэтгэмж	Материал хүлээн авч хэлтсийн даргаар гарын үсэг зуруулж тамга даруулдаг	110	110	116	934
2	Нөхцөлт мөнгөн тэтгэмж		561	519	523	4109
3	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн		461	453	460	4346
4	Өндөр настны рашаан сувилалын хөнгөлөлт		3	12	22	142
5	Жирэмсэн нярай эхчүүд		851	827	835	7357
6	Хүний хөгжил сангийн сан					
7	Алдарт эхийн одон		2	3	6	2016
	Нийт		1988	1924	1962	18904

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ: (Жаргалант сумын иргэний бүртгэл)

№	Үйлчилгээнийнэр	“НЦҮ”-нээс үзүүлж байгаа хэлбэр	Үйлчлүүлэгсдийн тоо \сараар\			Нийт жилийн эцэс өссөн дүнгээр
			X	XI	XII	
1	Төрөлт	шууд	69	75	54	868
2	Үрчлэлт	шууд	2	3	1	24
3	Гэрлэлт	шууд	20	25	15	267
4	Овог нэр өөрчлөлт	Шууд	7	8	5	86
5	Эцэг тогтоолт	шууд	14	11	12	150
6	Иргэний үнэмлэх	шууд	124	94	89	816
7	Шилжин ирсэн	шууд	147	154	99	1200
8	Шилжин явсан	шууд	136	132	82	1358
9	Нас баралт	шууд	14	6	8	165
10	Нөхөн бүртгэл	шууд	1	2	-	5
11	Гэрлэлт цуцлалт	шууд	4	5	1	25
12	Төрсний гэрчилгээ дахин олголт ИШБүртгэлтэй холбоотойгоор	шууд	15	11	28	150
13	Шинэчилсэн бүртгэл	шууд	205	198	269	1078
	Нийт		758	724	663	6192

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ: (Газрын харилцаа)

№	Үйлчилгээний нэр	“НЦҮ”-нээс үзүүлж байгаа хэлбэр	Үйлчлүүлэгсдийн Тоо \сараар\			Нийт жилийн эцэс өссөн дүнгээр
			X	XI	XII	
1	Иргэн, ААНБайгууллагын газар өмчлөх эзэмших, ашиглах, өмчлөх өргөдөл хүлээн авах, шийдвэр гаргуулах	Хурлаар	-	-	-	-
2	Иргэн, ААН, Байгууллагын эзэмших, ашиглах эрх шилжүүлэх шийдвэр гаргуулах	Хурлаар	-	-	-	-
3	Газар өмчлөх шийдвэр гаргуулах	Хурлаар	-	-	-	-
4	Иргэн аж ахуйн нэгж байгууллагад баталгаажсан кадастрын зураг	Шууд				758
5	Газарт зураглал хийсэн	Шууд				404
6	Иргэний газрын хэмжээ зөрүүтэй иргэдийн зөрчлийг тодруулсан	Шууд				134
7	Шилжилт хөдөлгөөн хийгдэж байгаа иргэдийн кадастрын зургийг хэвлэх	Шууд				212
8	Хяналтын хэмжилт	Шууд				86
9	Тойм зураг	Шууд				559
	Нийт					2153

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ: (Хөдөлмөрийн хэлтэс)

№	Үйлчилгээнийнэр	“НЦҮ”-нээс үзүүлж байгаа хэлбэр	Үйлчлүүлэгсдийн тоо \сараар\			Нийт жилийн эцэс өссөн дүнгээр
			X	XI	XII	
1	Жижиг дунд үйлдвэр	Зөвлөгөө мэдээлэл	4	5	3	70
2	Төсөл хөтөлбөр	Зөвлөгөө мэдээлэл	9	5	3	55
3	Ажлын байрны мэдээлэл, ажил хайгчийн бүртгэл	Зөвлөгөө мэдээлэл	20	13	8	123
	Нийт		33	23	14	248

ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТЭС